

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1081

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Монгол шинэчлэлт нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Монгол шинэчлэлт нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Монгол шинэчлэлт нам"-ын мөрийн хөтөлбөр /.....хүүдас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030676

Монгол Шинэчлэлт Намын  
2024 оны 03 дугаар сарын 20-ний  
Бага хурлын гуравдугаар хуралдааны  
01 тоот тогтоолыг батлав.



## МОНГОЛ ШИНЭЧЛЭЛТ НАМЫН 2024 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ


### МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол түмэнтэйгээ хамтран улс эх орноо нэн даруй шинэчлэн өөрчлөх түүхэн хариуцлагатай цаг үе ирээд байна. Монголын шинэчлэлт бол ганц МОНГОЛ ШИНЭЧЛЭЛТ намын бодлого биш бөгөөд бүх ард түмний хүсэл сонирхол, Монголоо гэх зүрх сэтгэлтэй улс төрийн нам, төрийн бус байгууллага, иргэний хөдөлгөөнүүд, нийт иргэдийн үүрэг хариуцлага, хүчин чармайлт тул Монгол улсынхаа нийт иргэдтэйгээ хамтран ХАМТДАА ШИНЭЧИЛЬЕ.

Монгол Шинэчлэлт намын мөрийн хөтөлбөрийн зорилго нь Монгол улсынхаа ард түмэн, иргэдтэйгээ хамт байж үзэл бодлоо нийлүүлж Үндсэн хуулиа дээдлэн ёс зүйтэй шударга ардчилсан нийгэм байгуулах, улс үндэстнийхээ түүхэн уламжлал, язгуур эрх ашиг, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, Монгол улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг улам бататган бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.

Монголчууд бид үндэсний хийгээд нийгмийн эрх ашгаа ухамсарлан нэгдэн нягтарч, дэлхий нийтийн шинэ нөхцөл байдал, хандлага, сэтгэлгээ, үзэл санаанд тулгуурлан Монгол Шинэчлэлтийг хийх түүхэн цаг үе, шаардлага, хөгжлийн шинэ замыг тодорхойлох ЦАГ ИРЛЭЭ.

Монгол Шинэчлэлт нам нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиудыг чандлан сахиж, хуулийн хүрээнд энэхүү Монгол төрийн бодлогын залгамж халааг үргэжлүүлсэн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг удирдлага болгож ажиллана.



00000001

## МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

### Нэг. Нийгмийн бодлого

- 1.1 Эрүүл иргэд-Эх үрс
- 1.2 Боловсролтой иргэд
- 1.3 Ажилтай орлоготой гэр бүл
- 1.4 Ахмад настан Зорилтот бүлэг
- 1.5 Спорт, соёл урлаг, эх оронч, хамтач үзэл, хүмүүжил
- 1.6 Шинжлэх ухаан инновацийн хөгжил

### Хоёр. Эдийн Засгийн бодлого

- 2.1 Экспортлогч аж үйлдвэр
- 2.2 Хувийн хэвшил – Ажлын байр
- 2.3 Экологид ээлтэй газар тариалан
- 2.4 Нүүдлийн онцлогтой эрчимт мал аж ахуй
- 2.5 Урт хугацааны стратегийн хөгжлийн бодлого
- 2.6 Хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод төсөв, мөнгөний бодлого
- 2.7 Уул уурхайн хөгжил

### Гурав. Ногоон хөгжил байгаль орчин

- 3.1 Ногоон хөгжил – Байгаль
- 3.2 Эко систем – Байгаль хамгаалал
- 3.3 Аялал жуулчлал - Эрүүл орчин

### Дөрөв. Төрийн бодлого Засаглал

- 4.1 Тогтвортой хариуцлагатай, иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээ
- 4.2 Хууль шүүхийн тогтолцоо - эрхзүйн шинэтгэл
- 4.3 Аюулгүй байдал - батлан хамгаалах бодлого
- 4.4 Харилцан ашигтай гадаад бодлого

### Тав. Нийслэл орон нутгийн хөгжил

00000002

## Монгол Шинэчлэлт намын мөрийн хөтөлбөр

### Нэг. Нийгмийн бодлого

#### 1.1 Эрүүл иргэд – ирээдүйн монгол хүн - эрүүл мэндийн салбарын шинэчлэл

- Иргэн бүрийн эрүүл мэндийн мэдлэг боловсролд тулгуурласан, өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлийг эрхэм болгосон эрүүл мэндийн цогц тогтолцоог бэхжүүлэн хөгжүүлнэ. Үүний хүрээнд ард иргэдээ шинжлэх ухаанд суурилсан зөв хоололтыг хэвшүүлж, урлаг, спорт, хөдөлгөөнөөр хичээллэх явдлыг БҮХ НИЙТИЙН ЖУРАМ болгоно.
- Шинээр эмнэлэг барьж байгуулах, гадаад улс оронд эмчлүүлэгчдийн гадагшаа урсаж байгаа мөнгөн урсгалыг дотооддоо үлдээхийн тулд эмнэлгийн эмч боловсон хүчний чанар чансааг сайжруулан Ази болон Европын улсуудад мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад бүрэн хамруулах, эх орондоо эмчлэх бололцоо, ахуй нөхцөлийг хангах төсөл санаачилж төрөөс бодлогоор дэмжиж ажиллана.
- Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд аймаг, хот, сум дундын эмнэлгүүдийн материаллаг бааз эмчилгээний тоног төхөөрөмжийг орчин үеийн болгож, дээд түвшний оношлогоо эмчилгээний төвүүд болгох шат дараалсан цогц арга хэмжээг авна.
- Эх орныхоо ирээдүй болсон хүүхэд эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндэд онцгой анхаарч, өөр хоорондоо уялдаагүй, саланги тусгай, замбараагүй олон бодлого, бодлогын баримт бичгүүд нь тус болохоосоо саад болох нь элбэг тул эмэгтэйчүүдийн, хүүхдийн, залуучуудын, гэр бүлийн, ахмад настны, эмзэг бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт баримт бичгүүдийг нэгтгэн системчилж, уялдаа холбоог сайжруулсан шинэчлэлтийг хийж "ШИНЭ ҮЕИЙН ЭРҮҮЛ ГЭР БҮЛИЙН ТӨЛӨӨ" үндэсний нэгдсэн шинэчлэлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарын бодлого, төсөв, санхүүжилт, үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг бий болгож, авлига, ашиг сонирхлын тогтолцоог устгана.
- Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлогын бичиг баримт, төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж, хувийн хэвшлийн оролцоог илүү хангасан эрх зүйн орчин бүхий стратеги, төсөв, төлөвлөгөө, төсөл хөтөлбөр боловсруулж нэвтрүүлэн хэрэгжүүлнэ.
- Эмийн бодлогыг шинэчилж, иргэд, үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай эм, эмийн хэрэгслээр хангах нөхцлийг бүрдүүлэх механизм бий болгоно.
- Вакцин, эмийн хяналтын үндэсний лаборатори байгуулна.
- Эмч, эмнэлгийн ажилтны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн батлуулж, бүх шатны эмнэлгийн байгууллагын ажилтнууд, эмч, сувилагчдын нийгмийн байр суурь, үнэлэмж, хүндлэлийг нэмэгдүүлэх, эрүүлийг хамгаалах мэргэжлийн нэр хүнд, эрүүл мэндийн ажилтны үнэлэмжийг нэмэгдүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашгийг эрс сайжруулна.
- Эрүүл мэндийн даатгалыг шилждэг, барьцаалдаг эрх зүйн орчинг бий болгоно.
- Эрүүл мэндийн санхүүжилтийн бүтцийг оновчтой болгох замаар, эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг бэхжүүлэн, иргэд эрүүл мэндийн үйлчилгээг оршин суугаа газрын харьяалал, өмчийн хэлбэр үл харгалзан эрүүл мэндийн даатгалаараа бүх шатлалын үйлчилгээг авах боломжийг бүрдүүлнэ.

00000003

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төсөв санхүү, нөөцийг нэмэн өргөжүүлж иргэдэд хүртээмжтэй ойртох нөхцлийг бий болгоно.
- Эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбарын шинэ технологи нэвтрүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүргийг оновчтой нэвтрүүлж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай зөв хослуулна.
- Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг орон нутагт бүрэн нэвтрүүлнэ.
- Анхан шатны тусламж үйлчилгээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж хүртээмж, хүчин чадал, хүний нөөцийг өргөжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрөөс онцгойлон анхаарах бодлого баримтална.
- Хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

## 1.2 Боловсролтой иргэд

- Үндэсний боловсролын тогтолцоог бий болгож сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх соёл, өв уламжлал, уйгаржин Монгол бичиг үсэгт тулгуурлан шинэчилж, сурагчдад эх оронч хүмүүжил боловсрол олгоход чиглэсэн хууль, тогтоомжийн шинэчлэлийг хийнэ.
- Боловсролын салбарын удирдах ажилтан аль ч шатны сургуулийн багш сурган хүмүүжүүлэгчдийг чадваржуулах мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулж, багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, сурагчдын амжилтаас хамаардаг цалин урамшууллын шинэ систем бий болгоно.
- Боловсролын системд нэн даруй өөрчлөлт хийж төрийн өмчийн сургуулийн чанарыг сайжруулан бүх ард түмний хүүхэд тэгш эрхтэй суралцах шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролыг "хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх" гэсэн зорилгоос илүүтэйгээр хүн болон төлөвших үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны агуулга, төрөл, хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдүүдийг бүрэн хамруулах зорилгод хүрэх арга хэмжээнүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хууль журмыг ягштал биелүүлдэг, бусдыг хүндэтгэдэг, цаг баримталдаг, үнэний төлөө, зөв үйлийн төлөө, шударга ёсны төлөө тууштай тэмцэх ёс зүйн хүмүүжлийг бага наснаас нь суулгах, нийгмийг гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.
- Бүрэн дунд боловсролыг мэргэжлийн сургалттай хослуулсан аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн гүнзгийрүүлсэн сургалтыг төрөөс бодлогоор дэмжинэ.
- Сурагчдыг нийгмийн харилцаанд ороход нь бэлтгэж, сэтгэл судлал болон хүн хоорондын харилцааны соёлын талаарх хичээлийг боловсролын хөтөлбөрт тусгана.
- Чанар муутай хувийн бага, дунд, дээд, их сургуулиудыг хаах, чанартай боловсрол эзэмших, эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах, гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлого боловсруулна.

00000004





- Улсын их, дээд сургуулиудын сургалтын чанар чансааг сайжруулан жинхэнэ мэдлэг боловсролтой хүүхдүүдийг сонгон шалгаруулж боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн төрийн оновчтой бодлогыг баримтална.

- Судалгааны их сургууль болон хөгжих үйл явцыг төрөөс идэвхитэй дэмжинэ.

- Байгалийн ухааны чиглэлийн мэргэжилтэн бэлдэх, инженер мэргэжилтэнг сурган боловсруулахад төрөөс идэвхитэй дэмжлэг үзүүлнэ.

- Аж үйлдвэрийн хөгжлийн эрин үеийн шаардлага, чадварт нийцсэн боловсон хүчнийг бэлтгэх боловсролын бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

- Оюутны сурах, амьдрах орчинг дээшлүүлэх, үр өгөөжтэй суралцаж өндөр мэдлэг эзэмших цогц бодлого боловсруулна.

- Сургалтын төрийн сангийн зээлд хамрагдах үйл явцыг нээлттэй, шударга явуулж, олгогдож буй тэтгэлэгийг ил тод болгож, менежментийг сайжруулна.

- Боловсролын гадаад харилцааг өргөжүүлж, Засгийн газар хоорондын хэлэлцээрээр хүлээн авч буй орны зардлаар сурах оюутны тоог эрс нэмэгдүүлнэ

- Авъяас чадварыг хөхүүлэн дэмжихээс гадна эрдэмтдийн ирээдүйтэй төслийг дэмжинэ.

- Дотоодын мэргэжил үйлдвэрлэлийн сургалтын төвүүдийг нэмэгдүүлэн суралцагчид мөнгөн тэтгэмж авахын зэрэгцээ эзэмшиж буй мэргэжлийнхээ чиглэлээр төр, хувийн хэвшилд суралцагч, дадлагажигчаар ажиллан хөдөлмөрийн хөлс авах замаар орлогоо нэмэгдүүлэх, улмаар төгсөөд ажлын байраар хангагдах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, хүний нөөц бүрдүүлэх эрх зүйн орчинг бий болгосон төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

- Багш бэлдэх тогтолцоог либеральчлах, төрийн өмчийн их дээд сургууль дахь багш бэлтгэх сургалт, хөтөлбөрийг амьдралд ойр чадвар, чадамж олгоход чиглүүлнэ.

- Хөдөө орон нутагт болон алслагдсан бүсэд багшлах багш нарыг төрөөс дэмжинэ.

- Багшийг дахин сургах, гадаадад сургах, туршлага солилцуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### 1.3 Ажилтай орлоготой гэр бүл

ATA9693 9006109  
9023030583

- Залуучууд болон хөдөлмөрийн чадвартай ажилгүй иргэдийг ажилтай болгож ажилгүйдлийг бууруулах, хөдөө орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, хот хөдөөгийн ялгааг арилгах, дэд бүтцийг сайжруулах, их дээд сургуулиудыг аймгуудад төвлөрүүлж залуу боловсон хүчнийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад чиглэсэн цогц бодлогыг боловсруулж, эрх зүйн орчныг бий болгож хэрэгжүүлнэ.

- Төрөөс залуучуудын амьдралыг дээшлүүлж гадагшаа явж ажиллах урсгалыг зогсоон эх орныхоо бүтээн байгуулалтад оролцож сайхан амьдрах үндэсийг бий болгоно.

- Бүх салбарын ажилчдын цалинг инфляцтай уялдуулан эдийн засгийн тооцоотойгоор нэмэгдүүлнэ.

- Үр ашиг муутай, салангид төлөвлөлтгүй өөр хоорондоо уялдаагүй, явцуу өнөөгийн эдийн засгийн үрэлгэн тогтолцоог халж, Монгол орноо аж үйлдвэр – хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэл давамгайлсан үндэсний болон бодит эдийн засгийн нэгдмэл системийг бүрдүүлнэ.

00000005



- Хүн ардынхаа хүнс, тэжээлийн хэрэгцээг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр найдвартай хангаж, гадагш экспортлох нөөц бүрдүүлэх чадвартай уламжлалт болон эрчимжсэн технологийг оновчтой хослуулсан мал аж ахуй, газар тариалан, тариалан, жимс ногоо боловсруулах үйлдвэрийн цогцолборуудыг хөдөө орон нутагт бүсчлэн байгуулна.
- Мал аж ахуйн түүхий эдийг өөрийн орны болон умард сэрүүн хүйтэн бүс нутгийн хэрэгцээнд зориулан өндөр технологиор боловсруулж, сайн чанарын бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадаатай хөнгөн үйлдвэрийн цогцолборуудыг оновчтой байгуулна.
- Эх орны эрдэс баялгийг хамгийн үр ашигтай олборлон технологийн шатанд хүртэл боловсруулж дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортын тогтвортой эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэсэн уул уурхай, металлургийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Улс орны нийгэм ахуй, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг бүрэн хангаж, дотоод зах зээлээ эзлэх хүчин чадал, технологи бүхий барилгын материал, барилга үйлдвэрлэлийн цогцолборыг төрөөс бодлогоор дэмжинэ.
- Ажиллах хүч, хөрөнгө, хөдөлмөрөө нэгтгэн хоршоолох, нэгдэх, хамтран ажиллах бүх төрлийн хэлбэрүүдийг төрөөс бодлогоор дэмжинэ.
- Стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг төрийн оролцоо хяналттайгаар өмнө гаргасан алдаанаас сургамж авч, алдааг засан түүнээс орсон орлогыг иргэдэд ноогдол ашиг болгон нэн тэргүүнд хуваарилахад бус эдийн засгийн үр ашигтай эргэлтэд оруулж, улс орны хөгжлийн чанартай дэд бүтэц, бүтээн байгуулалтанд оновчтой зарцуулснаар ард иргэдэд өгөх ноогдол ашгийн үр өгөөж, орлогыг нэмэгдүүлэх бодлогыг барина.
- Хөдөөгийн иргэдийн арьс шир, ноос, мах сүү, газар тарилан, төмс хүнсний ногоо, хүлэмж, загас загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүс нутаг болон орон нутгийн онцлогт тохируулан байгуулах ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг өсгөх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж өрхийн болон бичил зээлийн хүртээмжийг дээшлүүлэх замаар хувийн хэвшлийг бүх талаар дэмжин, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулж, чинээлэг дундаж давхаргынхны тоог өсгөнө.
- Нийгмийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн орлогын ялгааг мэдэгдэхүйц багасгахад чиглэсэн эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлж, нийгэмд дундаж орлоготой хүчирхэг давхаргыг тэлэх бодлого барина.
- Нийгмийн баялгийг зохистой, шударга хуваарилах, эдийн засгийн хөгжлийг тэтгэх татварын оновчтой бодлогыг хэрэгжүүлж, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан татварт хамруулна. Хүн амын орлогын өсөн нэмэгдэх шатлалтай татварын зарчмыг нэвтрүүлнэ.
- Ажлын байрыг бий болгох замаар ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүргэж, тогтвортой бууруулна.
- Ядуурлаас гарахад зориулсан мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулж, сургалтыг төрөөс тогтмол явуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, бүрэн хөдөлмөр эрхлэлттэй улс болохын төлөөх бодлого хэрэгжүүлнэ.
- Нийгмийн халамжийн хүртээмж, оновчтой байдлыг сайжруулах, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааны баталгааг хангахыг зорино. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд олгогдох нийгмийн халамжийг

00000006

өрхийн үндсэн хэрэгцээнд хүрэлцэхүйц хэмжээнд хүргэхээр өнөөгийн нийгмийн халамжийн тогтолцооны бодлого, зохицуулалтыг шинэчилнэ. Бага насны хүүхэд ядууралд өртөх, хүнс тэжээлийн дутагдалд орох, орон гэргүйн улмаас амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь эрсдэх нөхцөл байдлыг арилгахад чиглэсэн бодлогын шинэчлэлийг хийнэ.

- Ипотекийн зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлж, орон сууцны түрээсээ байрныхаа урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг гадаад орны туршлагаас нэвтрүүлэх бодлого баримтална.

#### **1.4 Ахмад настан - Зорилтот бүлэг**

- Өндөр настнуудын амьдралын баталгааг хангах бодлогыг баримтална.

- Өнөөгийн тэтгэврийн даатгалын тогтолцоог суурь тэтгэврийн тогтолцоо болгон өөрчилж, тэтгэврийн даатгалын хувийн, хуримтлалын тогтолцоог нэвтрүүлнэ.

- Төрийн суурь тогтолцооноос гадна тэтгэврийн даатгалын албан журмын болон сайн дурын хувийн хуримтлалын тогтолцоог нэвтрүүлнэ

- Ингэснээр иргэд ирээдүйн тэтгэврийн насны орлогоо нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийх боломжтой болж, Монголчуудыг нийтээр нь ядууруулж байгаа өнөөгийн тогтолцоог хална

- Тэтгэврийн СОНГОДОГ тогтолцоонд шилжих эрх зүйн орчныг бий болгоно. Тэтгэврийн даатгалын хувийн, хуримтлалын тогтолцоог нэвтрүүлнэ.

- Ахмад настны талаар төрөөс баримтлах цогц бодлого гаргаж, ахмадад үзүүлэх асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, засаг захиргааны томоохон төвүүдэд ахмад настны асрамжийн газрууд болон эмнэлэг, сувиллуудыг шинээр байгуулахад анхаарна.

- Зорилтот бүлэгт хамаарагчдын нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх бодлого баримтлахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж ажиллана.

- Хүүхдийн мөнгийг тэдний эрүүл саруул өсч хүмүүжих, боловсрол эзэмших, амьжиргааны зайлшгүй шаардлага хэрэгцээг хангахад чиглүүлэх, ирээдүйн хуримтлалд зориулахад болон олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг одон тэмдгээр хуурах биш олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох урамшуулалыг нэмэгдүүлэх хуулийн төслийг санаачилна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд орох боломжийг бүрдүүлэх, цаашлаад ажил хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлэх.

- Цэцэрлэг, сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурах, ашиглах бүрэн боломжтой байх стандартыг нэвтрүүлж хэвшүүлнэ.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлдэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

#### **1.5 Спорт, соёл урлаг, эх оронч, хамтач үзэл, хүмүүжил**

- Бүх нийтийн биеийн тамир, спорт, иог, бясалгал, зохистой хөдөлгөөн фитнесээр хичээллэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжихийн хамт улс орон даяар "Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн" бүх нийтийн хөдөлгөөнийг сэргээн хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, үүнийг урамшуулан дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

00000007



- Ерөнхий боловсролын сургууль бүрд биеийн тамирын заал, спортын талбай байгуулж, хүүхэд багачуудын бие бялдрын хөгжил, эх оронч, хамтач үзэл хүмүүжлийг дээшлүүлнэ.
- Үндэсний эх оронч үзлийг төрийн үзэл суртлын гол чиглэл болгон Монголын түүх, монгол бичгийн үнэлэмжийг дээшлүүлэх "Бүх нийтийн эх оронч үзлийн" цогц хөтөлбөр боловсруулж, хүүхэд залуу үеийг үндэсний – эх оронч үзлээр хүмүүжүүлэх системийг бий болгосноор Монгол хүний хүмүүжлийн шинэчлэлийг тууштай хэрэгжүүлнэ.
- Шинжлэх ухааны болон соёлын бодлогыг шинэчлэн боловсруулж, шинжлэх ухаан, соёл урлагийн бүтээлийг суртачлах, үнэлэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- Монголын үндэсний болон дэлхийн түүх, соёл урлагийг улам дэлгэрүүлэн хөгжүүлэх явдлыг төрийн тусгай бодлогоор дэмжин сайжруулна.
- Гэр бүлийг бэхжүүлэх хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах таатай орчин бүрдүүлж, хүүхдүүдийг амьдрах ухаанд сургаж, зөв хүмүүжилтэй иргэн болгох цогц бодлого хэрэгжүүлнэ.

### 1.6 Шинжлэх ухаан инновацийн хөгжил

- Мэдлэгт суурилсан оюуны багтаамж бүхий инновацийн тогтолцоог цогцоор нь хөгжүүлэхийг төрийн бодлогоор дэмжиж, шинжлэх ухааны салбар хүрээлэнгүүд их дээд сургуулийн эрдэм шинжилгээ судалгааны ажлуудын чанар өгөөжийг дээшлүүлэхэд зориулагдах хөрөнгийг нэмэгдүүлж, тусгай бодлого хэрэгжүүлнэ.
- Үйлдвэрлэл ШУ-ны ололт иновацийн холбоог улам өргөжүүлэн экспортын эцсийн бүтээгдэхүүн гаргахад чиглэсэн бодлого явуулж, үр дүнд хүрнэ.
- Дэлхийн шилдэг технологи арга барилуудаас Монголд тохирохыг нь нутагшуулан, Монгол хүмүүсийн эзэмшиж буй зохиогчийн эрх патентыг Олон улсад сурталчлан хамгаалж, үнэлэмжийг нь нэмэгдүүлнэ.
- Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, хувийн хэвшлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Судалгаа-хөгжлийн төвүүдийг байгуулж, судалгаа шинжилгээний үр дүн нь зөв технологиор дамжин аж үйлдвэрийн салбарт үр нөлөөгөө өгдөг, мэдлэгт суурилсан бодит эдийн засгийг бий болгох үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ. Судалгаа-хөгжлийн төвүүдэд оруулсан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татвараар дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Нийгэмд тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, шилдэг техник технологиор шийдсэн гарааны компаниудыг үүсгэн бий болгох эрх зүйн болон бизнесийн таатай орчинг бүрдүүлэн, мэдлэгт суурилсан бизнесийн шинэ эх үүсвэрүүдийг бий болгоно.
- ШУА-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг сайжруулж, үр дүнд суурилсан санхүүжилтын тогтолцоонд шилжүүлнэ.
- Мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй дотоодын компаниуд, мэргэжлийн холбоодыг дэмжиж чадавхжуулах бодлого баримтлана.
- Төрийн байгууллагуудад мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийг нэгдсэн удирдлага уялдаа холбоогоор хангах. Одоогоор 800 гаруй тэрбум төгрөгийн мэдээллийн технологитой холбоотой төслүүд хэрэгжиж байна. Харамсалтай нь давхцал болон үргүй зардал ихтэй байгааг цэгцэлнэ.
- Төрийн үйлчилгээг цахимжуулж нийгмийн стрессийг бууруулна.

00000008



- Төрийн мэдээллийн өгөгдлийг бий болгон хөгжлийн бодлого төлөвлөлтийг хийдэг болох, төрийн аливаа шийдвэрүүдийг судалгаа, мэдээлэлд суурилж гаргадаг болно.
- Мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжих бодлого баримтлана.
- Гадаадад мэдээлэл харилцааны технологийн чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийг эх орондоо ирж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлнэ. Гадаадад авдаг цалингаар эх орондоо ажиллах боломжийг бүрдүүлж гадагш чиглэсэн ажиллах хүчний урсгалыг зогсооно.
- Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулна.
- Хөгжлийн хандлагыг даган танхимын бус, зөвхөн хүүхэд залуус биш бүх насны хүмүүст зориулсан онлайн, эчнээ сургалтуудыг нэвтрүүлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх боломжийг технологид суурилан олноор бий болгоно.
- Шинэ технологийг шуурхай нэвтрүүлэх. Блокчэйн болон бусад шинэ технологид суурилсан шинэ бизнес, кластер, бүтээгдэхүүн, шийдлүүдийг цаг алдахгүй, бусдаас өрсөн нэвтрүүлж хөгжүүлэхийг дэмжинэ.
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлнэ. Үндэсний хиймэл дагуулыг төрөлжүүлэн хөөргөхийн сацуу энэ чиглэлээр олон улсын үндэстэн дамнасан томоохон корпорациудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлнэ.

## Хоёр. Эдийн засгийн бодлого

### 2.1 Экспортлогч Аж үйлдвэр

- Төсөв, мөнгө, гадаад худалдаа, татвар, үнэ, ханш, хүүгийн харилцан нягт уялдаатай, гадаад дотоод орчны өөрчлөлтөд түргэн зохицох макро эдийн засгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.
- Улсын зээлжих зэрэглэлийг ахиулж гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- Засгийн газрын өрийг удирдаж, зохистой түвшинд хязгаарлана.
- Дотоодын бондын зах зээлийг блокчэйн технологи дээр тулгуурлан хөгжүүлж хөрөнгийн зах зээлийг эрчимжүүлнэ.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлж төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл хийх бодлого баримтлана. Салбарын болон орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцоолж, улсын нийгэм эдийн засгийн хөгжилд түлхэц болох төслүүдийг эрэмбэлэн санхүүжүүлж, хөрөнгө оруулалтын шийдвэр болон санхүүжилтийг ил тод болгоно.
- Жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1/3 хэсгийг улсын чанартай дэд бүтцийн хөгжил, инноваци, ажлын байр нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд зориулах бодлого баримтлана.

00000009

- Эдийн засгийн мөчлөгийн сөрөг нөлөөг сааруулах тогтворжилтын болон хуримтлалын санг арвижуулна.

- Өөрийн орны эдийн засгийн харьцангуй давуу тал дээр үндэслэн өрсөлдөх чадвар бүхий уул уурхай, МАА, газар тариалан, МАА-н дагавар бүтээгдэхүүнд суурилсан боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэн, эдийн засгийн зохистой бүтцийг бий болгох бодлого баримтлана.

- Эдийн засгаа тэтгэх банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн хүчирхэг тогтолцоог хөгжүүлж, финтекийн салбарыг бэхжүүлж, бүс нутагтаа өрсөлдөхүйц хэмжээний үндэсний корпорациудыг тэтгэн хөгжүүлэх бодлого баримтална.

- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд нийгмийн даатгалын сангууд бусад институционал хөрөнгө оруулагчдыг жам ёсных нь дагуу хөрөнгийн зах зээлд татна.

- Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйг тэргүүн ач холбогдол бүхий салбарын түвшинд авч үзэж хөгжүүлнэ. Нийслэл, орон нутгийн олон хүн амтай хотын эргэн тойронд уламжлалт мал аж ахуйг орчин үеийн фермерийн аж ахуйтай хослуулан хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргах бодлого хэрэгжүүлнэ.

- Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцлийг бүрдүүлнэ.

- Хүйтнийг даван туулах технологийг бүхий л талаар дэмжин, дулаан алдагдал багатай барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтална.

- Уул уурхайн олборлох салбарт тулгуурлан аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, нүүрс-хими, нефть-хими, эрчим хүч, дэд бүтцийн салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгнө.

- Манай улсын харьцангуй давуу тал болох аялал, жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ.

- Мэдлэг, инновацийг дээдэлсэн эдийн засгийн ач холбогдолтой бизнесийн төслүүдийг дэмжинэ.

- Малчид, мал аж ахуйн хөдөлмөр эрхлэгчдийн ахуй соёл, нийгмийн хангамжийг шинэ шатанд гаргах бодлого баримтална.

- Мал аж ахуй, ХАА-н үйлдвэрлэл, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэн ялангуяа мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлд гадны зээл тусламжийг ашиглах бодлогыг баримтална.

- Хүнд болон хөнгөн үйлдвэржилтийн урт хугацааны бодлого баримтлан дотооддоо нефть боловсруулах үйлдвэрийн төслийг хугацаанд нь ашиглалтанд оруулж, улмаар химийн аж үйлдвэрийн суурь үүсгэж, цаашлаад нүүрс, занар, шингэрүүлсэн хий кокс-химийн бүтээгдэхүүнээр эх орноо ханган, экспортлох бодлого барин ажиллана.

- Дархан Сэлэнгийн бүс нутагт дахь хар төмөрлөг, металлургийн үйлдвэрлэлийг өргөтгөн төмрийн хүдрийг боловсруулан экспортод гаргана. Оюутолгой зэрэг том ордуудыг түшиглэн зэс хайлуулах, таван толгойн ордыг түшиглэн нүүрс бүрэн угаах цаашид гүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

00000010

- Хөнгөн болон Жижиг дунд үйлдвэрлэлийг улам илүү хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлж, импортыг орлох экспортод гаргах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэлхийн стандартад нийцэхүйц болгон хөгжүүлнэ.

- Импортыг орлуулж дотооддоо үйлдвэрлэж болох бүх, бараа таваарын импортын татварыг нэмнэ.

## 2.2 Хувийн хэвшил – Ажлын байр

- Ажлын байр бий болгож буй хувийн хэвшлийн байгууллага, жижиг дунд үйлдвэрлэлүүдийг төрөөс бодлогоор дэмжин хөрөнгө оруулалт хийн, хөнгөлөлттэй урт хугацааны зээл, татвар, даатгал, хуримтлалын талаар олон талын дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг улам боловсронгуй болгоно.

- Алслагдсан бүс хөдөө орон нутагт бизнес ажлын байр буй болгогчдыг дэмжин “Бүс нутагт үзүүлэх хөнгөлөлтийн бодлого” баримталж хэрэгжүүлнэ.

- Төрөөс бизнес эрхлэгчдэд олгодог тусгай зөвшөөрлүүдийн тоог илт багасгаж, хүчинтэй байх хугацааг нь уртасгаж, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлын дарамтыг багасгана.

- Эдийн засаг, бизнест хэт дарамт учруулахгүй, энгийн ойлгомжтой, үр нөлөө бүхий, шударга татварын тогтолцоог бий болгоно. Бизнесийн шударга орчин, шударга өрсөлдөөнийг бий болгоно.

- Хүн амын орлогын өсөн нэмэгдэх шаталсан татварыг нэвтрүүлж орлогын хэт ялгааг багасгах хөшүүрэг болгоно.

- НӨАТ-ийн хувь хэмжээ, хэрэгжүүлэх арга замыг эргэн харж, бага, дунд орлоготой иргэд, аж ахуйн нэгжид үүрэх татварын ачааллыг бууруулах бодлогыг судалгаа, эдийн засгийн тооцоололын үндсэн дээр боловсруулан УИХ-аар хэлэлцүүлнэ.

- Үйлдвэрлэлийг дэмжих төрийн олон сангуудын үйл ажиллагааг тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд хөшүүрэг болгох цогц арга хэмжээг бодлогын түвшинд боловсруулан хэрэгжүүлнэ.

- Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлэх бодлого баримтлана.

- Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дорвитой бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулна.

- Олон улсын туршлага, өөрийн орны боломж, нөхцөлд нийцүүлэн эдийн засгийн, экспортын, худалдааны чөлөөт бүсүүдийг хөгжүүлж, үйлдвэрлэлийг төрөлжүүлэх бодлого баримтлана.

- Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.

- Өргөн уудам нутагтай, хүн ам цөөтэй, жижиг зах зээлтэй улсын хувьд цахим худалдаа, үйлчилгээг хөгжүүлж, газарзүйн алслагдмал байдалтай холбоотой бизнесийн өртөг, зардлыг хямдруулна.

00000011



- Монгол улсад стандартын шинэтгэл хийх, стандартыг хөгжлийн түлхүүр гэж үзэж нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэх хөшүүрэг болгох бодлого баримтлана. Нэн тэргүүнд онцгой ач холбогдол бүхий салбаруудын стандартуудыг өөрийн орны хөгжлийн түвшин, онцлог, олон улсын чиг хандлагатай уялдуулан олон улсын стандарт, зарчим, хэм хэмжээг нутагшуулах замаар үндэсний стандартын тогтолцоог шинэчлэх бодлого баримтлана. Стандартыг техникийн хууль гэж үзэж, түүний хэрэгжилт, хариуцлагыг хуультай нэгэн адил түвшинд авч үзэх эрх зүйн орчинг бий болгож, сайжруулах бодлого баримтлана.
- Жижиг дунд үйлдвэрийн эрх зүй, зээлийн санхүү, эдийн засгийн асуудалд бүрэн шинчлэл хийж, хөгжлийн шинэ түвшинд гаргах бодлого баримтлана.
- Худалдааны хуулийг шинээр боловсруулан мөрдүүлж, худалдаа, үйлчилгээ эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх бодлого баримтлана.
- Иргэн бүрд жигд боломж, нөхцөлийг олгосон баялгийн шударга хуваарилалтыг хэрэгжүүлж, авлигаас ангид бие даасан, хэсэг бүлэг этгээдийн шунал, хүсэлд захирагдаагүй сахилга баттай шударга чөлөөт зах зээлийн эдийн засгийг тогтооно.
- Эдийн засаг, бизнест тэгш боломж, шударга өрсөлдөөнийг бий болгох зарчмыг мөрдлөг болгон, хөдөлмөрлөсөн нь сайхан амьдардаг, хичээсэн нь амжилт гаргадаг, хүний наад захын эрэлт хэрэгцээ хангагдсан, шударга нийгмийг цогцлон байгуулна.
- Бизнесийн салбарт бизнес эрхлэх шударга, тогтвортой орчинг бүрдүүлж, компанийн засаглал, бизнесийн ёс зүйг сайжруулж, зөвлөх үйлчилгээг дэмжинэ.
- Төрийн санхүүжилттэй нийтийн чанартай төсөл, засгийн газрын ханган нийлүүлэлтийн төслийн бараа үйлчилгээний тендер, худалдан авалтыг шударга явуулахад онцгой анхаарч, хэрэгжилтийг ил тод, нийтийн хяналтан дор явуулна.
- Гааль татварын тогтолцоо, Хөгжлийн банк, жижиг дунд үйлдвэрийн сан, газар тариалангийн сан, хөдөө орон нутгийн хөгжлийн сан зэрэг төрийн оролцоотой банк, санхүүгийн байгууллагуудын зээл олголтын стандарт, дүрэм журмыг боловсронгуй болгож, санхүүжилт нь очих ёстой эзэндээ хүрдэг байхад анхаарна.
- Дотоодын нөөц бололцоогоор хийх боломжтой ажлын байрыг хамгаалж, өөрийн орны иргэдийг ажиллуулах, эрэлт хэрэгцээ өндөртэй болон ирээдүйд шинээр бий болох ажлын байруудад боловсон хүчнийг сургах, бэлтгэх бодлого баримтлана.

### 2.3 Экологид ээлтэй газар тариалан

- Экологид ээлтэй газар тариалангийн бодлогыг Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулж, газрын үржил шим, үр өгөөжийг дээшлүүлэн, үрийн аж ахуйг улам сайжруулан, үр тариа, төмс ногоо, жимс жимсгэнэ, газар тариалангийн ургамал, бүтээгдэхүүнээр эх орныхоо хэрэгцээг бүрэн хангах бодлого хэрэгжүүлнэ.
- Газар тариалангийн орчин үеийн тоног төхөөрөмж, түүхий эд, материалын нийлүүлэлтийг гадны хандив, буцалтгүй тусламжинд тулгуурлан дэмжин, агуулах зоорь, хүлэмжийн аж ахуйг улам өргөтгөнө.
- Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого баримтлана.

### 2.4 Нүүдлийн онцлогтой эрчимт мал аж ахуй

00000012

*[Handwritten signature]*

- Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйг тэргүүн ач холбогдол бүхий салбарын түвшинд авч үзэж хөгжүүлэх бодлого баримтлана.
- Монгол орны бэлчээрийн талхлагдал, доройтол цаашид газар авахаас сэргийлэх, мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хангахад тулгуур ач холбогдол бүхий "Бэлчээрийн тухай хууль"-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Монгол орны үл олборлогдох нөөц төдийгүй хөдөөгийн хөгжил, үндэсний соёлын өв болсон бэлчээр нутгаа хадгалан хамгаалах "Бэлчээр ашиглалтын тухай хууль"-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Нүүдлийн онцлогтой мал аж ахуйн хөгжлийг бодлогоор дэмжинэ.
- Нутгийн болон шилмэл малын удмын санг хамгаалан, ашиг шимийг нь дээшлүүлэхэд тусална.
- Мал сүргийг байгалийн гамшгаас хамгаалах цогц бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Малыг гоц халдварт өвчнийг оношлох эмчлэх түүнтэй тэмцэх ажлыг сайжруулна.
- Мах махан бүтээгдэхүүний боловсруулалтыг гүнзгийрүүлэн экспортын зах зээлийн өргөтгөх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Малыг түүхий эд болох арьс шир, ноос ноолуурын чиглэлээр ангилсан ферм байгуулж дахин боловсруулалт хийж дотоодын жижиг дунд үйлдвэрт ашиглах.
- Монгол орны 70 гаруй хувийг хамардаг бэлчээрийн өөрийнх нь сэргэх чадавх болон малчдын хамтын оролцоонд тулгуурлан нутгийн тогтвортой ашиглалтыг хангах хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого баримтлана.
- Мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг экспортлоход тэргүүн ач холбогдол өгнө.
- Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан хот суурин газруудын ойролцоо эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх бодлого баримтлана.
- Сум болгонд малын эрүүл ахуйг хангах, түүхий эд цуглуулах төвүүдийг өмчийн олон хэлбэртэйгээр байгуулж хөдөө аж ахуйн биржтэй хослон ажиллуулах бодлого баримтлана.
- Арьс шир, мах, сүү, ноос зэрэг малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэнд оруулах санаа санаачлагыг дэмжиж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлэх,
- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн гинжин хэлхээг бүрэн болгож, төгөлдөршүүлэх,
- Мал аж ахуй, хөдөө аж ахуйн эрүүл бүсийг бий болгож, баталгаажуулах,
- Мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах салбарыг төрөөс тууштай дэмжих бодлого баримтлана.

00000013

- Дэлхийн тэргүүлэх улс орнуудын хөгжлийн хандлага шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололтууд, Монгол орны онцлогтой уялдуулан улс орны урт, дунд, ойрын үеийн зорилтуудыг бүхэлд нь буюу хэсэгчилсэн байдлаар салбар хоорондын уялдаа холбоотойгоор тусгасан улс орны хэмжээнд хэрэгжүүлэх стратеги, хөгжлийн бодлогуудыг нэгтгэн нэгдсэн нэг бодлогоор улс орны хөгжлийг удирдан зохион байгуулахад хувь нэмрээ оруулна.

## **2.6 Хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод төсөв мөнгөний бодлого**

- Улсын төсвийн зориулалтын үр ашгийг дээшлүүлэн хэмнэлттэй хариуцлагатай байдлыг бататган, алдагдлыг бууруулна.

- Төсвийн ил тод байдлыг хангаж, санхүүгийн аудитын үр ашгийг дээшлүүлэн түүний мөрөөр хуулийн хүрээнд тооцох хариуцлагыг өндөржүүлэн ажиллана.

- Банкны системийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгоно. Эдийн засаг, нийгмийн хөгжлийг мөнгөний бодлогоор дэмжиж, үр ашгийг дээшлүүлнэ.

- Инфляцийг тогтвортой нам дор түвшинд барина.

- Хөрөнгийн урсгалыг зохицуулалттай болгож, гадаадын банкууд тэнцвэртэй ажиллах эрх зүйн орчинг нээх замаар бизнесийн зээлийн хүүг тууштай буулгах бодлого баримтална.

- Үнэ, ханшийг тогтвортой түвшинд байлгах, эдийн засгаа дэмжин тэтгэх мөнгөний зөв бодлого хэрэгжүүлнэ.

- Гадаад валютын нөөцийг олон улсын нийтлэг жишиг түвшин, зохистой хэмжээнд хүргэнэ.

- Төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангана.

- Банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.

## **2.7 Уул уурхайн хөгжил**

- Уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэн борлуулах, зах зээлийг өргөтгөнө.

- Нүүрс, алт, жонш, зэс, төмрийн хүдэр болон бусад түүхий эдийн олборлолтын шинэ хүчин чадлыг бий болгож дотооддоо анхан шатны боловсруулалт хийнэ. Экспортлох үйл ажиллагааг цогцоор нь хийнэ.

- Уул уурхайн тоног төхөөрөмжийн шинэ технологи, менежментийг үр ашигтайгаар нутагшуулан, уул уурхайн үндэсний боловсон хүчнийг бэхжүүлнэ.

- Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангана.

- Уул уурхайн төрийн өмчит томоохон компаниудыг улс төрчид ба намын нөлөөллөөс ангижруулж, иргэдийн хяналттай нээлттэй хувьцаат компани болгож, Монгол Улсын иргэд, төр, бусад хувьцаа эзэмшигчдийн тэнцвэрт харилцааг тогтооно.

- Оюу Толгойн үйлдвэрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах цахилгаан станц байгуулах бодлого баримтална.

00000014

- Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангах бодлого баримтлана.

- Устөрөгчийн эх үүсвэртэй эрчим хүч, тээврийг дэмжих үйлдвэрлэл, нүүрснээс хий гаргах, биомассын эрчим хүч үйлдвэрлэх, цахилгаан эрчим хүчийг зай хураагуур болон бусад хэлбэрээр хадгалдаг технологийг хөгжүүлнэ.

- Улсынхаа харьцангуй давуу тал, экспортын зах зээлийн хандлага, хөгжлийн тэргүүлэх чиглэлд тулгуурлан Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

- Тэргүүний технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.

- Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.

- Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа мах, сүүг 100 хувь үйлдвэрлэлийн аргаар боловсруулна.

- Улс орны дэд бүтцийн бүтээн байгуулалтад гол орц болох ган, цемент, шилний үйлдвэрт тэргүүлэх ач холбогдол өгч хөгжүүлнэ. Уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган, цемент, шилэн хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.

- Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангах бодлого баримтлана.

- Монголын компаниуд, өндөр технологийн компаниудыг олон улсын зах зээлд гарахыг төрөөс дэмжих бодлого баримтлана.

## **Гурав. Ногоон хөгжил байгаль орчин**

### **3.1 Ногоон хөгжил - байгаль**

- Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлнэ.

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зөв ашиглан, нөхөн сэргээхэд төрийн ба төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлнэ.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, санхүүгийн тогтвортой эх үүсвэр бий болгоно.

- Байгальд ойр Монгол загварыг хөгжүүлнэ.

- Уламжлалт нүүдлийн МАА болон малчин Монголчууд байгаль орчинтойгоо ойр амьдарч ирсэн тул өнөөгийн дэлхийн байгаль орчны бохирдол, хотжилтоос зайлсхийсэн ирээдүйг харсан загварыг хөгжүүлэх, бүх салбаруудад байгаль орчинд ээлтэй соёлыг нэвтрүүлэх, бизнесийн боломж олгоно.

- Дэлхийн дулаарал, хүлэмжийн хийг бууруулах технологи, ногоон санхүү, бизнесийн систем хөгжүүлэн, ногоон бизнесийн мэдлэг, санхүүгийн олон улсын төв болох бүрэн боломжтой уламжлалт өгөгдлөөрөө дэлхийн олон нийтэд танигдан

00000015



имижээ бүрдүүлж, бусад улсуудыг манлайлж, эдийн засгийн өсөлтийн нэг тэргүүлэх чиглэл болгоно.

### 3.2 Эко систем – Байгаль хамгаалал

- Хэрэгжүүлж буй бодлого, гаргаж буй чармайлт, төслүүдийн үр дүнгээр дэлхийн бусад улсыг манлайлан үлгэрлэнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгоно.
- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлого баримтлана.
- Хүлэмжийн хий бууруулах, байгаль хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга, ногоон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, санхүүжилт, хөрөнгө оруулалт татах зориулалттай төр хувийн хэвшил хамтарсан санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх бодлого баримтална.
- Хувийн хэвшлийн оролцоо, хариуцлага, хөрөнгө оруулалтыг түлхүү татан оруулах, ногоон зээл санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын орчин бий болгоно.
- Ой түүний дагалдах баялгийг зохистой ашиглах, ойжуулахад оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.
- Хөрсөн дээрх болон доорх усны бодлогын шинэчлэлтийг эрчимжүүлнэ.
- Нийслэл болон хотуудын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авна.
- Хог хаягдлыг ангилах тээвэрлэх, дахин боловсруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.
- Орон нутаг, байгаль дахь хог хаягдлыг арилгах, түүж цуглуулах тогтолцоог боловсронгуй болгож, аялал жуулчлалын орлогоос хог хаягдлыг бууруулах менежментийг санхүүжүүлнэ.
- Усны бохирдлыг бууруулна. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх зорилгоор арга хэмжээнүүдийг авч эхэлнэ.
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.

00000016

- Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.

- Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй хот болгоно.

- Дахин сэргээгдэх ан агнуурын нөөцийн менежментийг хөгжүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

### 3.3 Аялал жуулчлал – Эрүүл орчин

- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, байгалийн аялал жуулчлалтай нягт уялдуулна.

- Аймаг орон нутгийн аялал жуулчлалын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан, аялан жуулчлалын нэгдсэн мэдээллийн санг бий болгоно.

- Байгалийн үзэсгэлэнт, онцгой газруудыг түшиглэн аялал жуулчлалын дэд төвүүд байгуулан ажиллана.

- Жуулчдын аялах тав тухтай орчин нөхцөлийг сайжруулах /стандартад нийцсэн ариун цэврийн өрөө, хоолны газар, үйлчилгээний газар/. Эртний түүх дурсгалт газруудыг сэргээн засварлаж аялал жуулчлалын төвийг бий болгох.

- Төрөөс аялал жуулчлалын чиглэлээр гадаад болон дотоодын жуулчдыг татах зорилгоор томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж ажиллана. Тухайлбал: Чингис хааны төрсөн нутаг болох Хэнтий аймгийн Дадал суманд Чингисийн онгоныг шинээр бүтээн байгуулах, Архангай аймаг Цахир сум дахь хүрээ сүм хийдийг шинээр сэргээн босгох.

- Аялал жуулчлалын үйлчилгээг олон улсын түвшинд хүргэж, экспортын орлогын тогтвортой эх үүсвэр болгох бодлого баримтална.

- Монгол улсын аялал жуулчлалын харьцангуй давуу талыг харгалзан байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал, нүүдлийн соёл иргэншлийг танилцуулах жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх бодлого баримтална.

- Аялал жуулчлалын үйлчилгээний олон улсын стандартыг нэвтрүүлж, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулна. Аялал жуулчлалын олон төрөл, улирлын онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална.

- Жуулчдын тоог нэмэгдүүлнэ. Агаарын тээврийг хөгжүүлэх, агаарын замыг олноор нээх, гадны хөрөнгө оруулагчдыг уг салбарт түлхүү оруулан нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар тийзийн үнийг яаралтай бууруулж, жуулчдын тоог өсгөх.

- Орчин үетэй зохицон хөгжиж нүүдлийн соёл, ахуйтай танилцах болон байгаль орчинд ойр, эрүүл амьдралын хэв маягийг мэдрүүлсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлэх.

- Музей, соёл урлаг, түүх, уламжлалт зан заншилыг хамарсан зөөлөн хүчний бодлогыг аялал жуулчлалтай уялдуулна.

### Дөрөв. Төрийн бодлого засаглал

#### ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

00000017

- Монгол улсын засгийн эрх мэдэл ард түмний мэдэлд байх үндсэн агуулгын хүрээнд тогтолцоогоо өөрчилж, шинэчлэх асуудлыг олон нийтийн санал асуулга дээр үндэслэн шийдвэрлэнэ.

- Төрийн албыг улс төрийн зорилгоор наймаалцах явдлыг үгүй хийнэ.

- Улс төрийн томилгоо, хууль бусаар төрийн албан хаагчийг халах байдлыг өөгшүүлж ирсэн өнөөгийн байдлыг таслан зогсоож, Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн найруулна. Чингэхдээ төрийн захиргааны албан хаагчид тусгайлан гаргасан хууль болгож, төрийн үйлчилгээ, тусгай, улс төрийн албан хаагчид болон орон нутгийн албан хаагчдад зориулсан бие даасан хуулийг боловсруулан мөрдүүлэх бодлого баримтална.

#### 4.1 Тогтвортой хариуцлагатай, иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээ

- Төрийн институцүүдийн харилцан уялдаа, хяналттай ажиллах тогтолцоог боловсронгуй болгож, төрийн нэр хүнд чадавхыг улам дээшлүүлнэ.

- Төрийн албаны шинэтгэлийн цогц бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

- Иргэдийн санал хүсэлтэд шуурхай хандаж, хүнд суртлын чирэгдлийг арилгах шийдвэртэй арга хэмжээ авч, төрийн байгууллагыг илт тод нээлттэй хяналттай байлгах журмыг улам боловсронгуй болгоно.

- Төр иргэний нийгмийн байгууллага гишүүдийн хамтын ажиллагааг улам эрчимжүүлэн улс орны нийтлэг асуудлаар зөвшилцөлд хүрэх зөв механизм тогтооно.

- Төрийн үйлчилгээг цахимжуулж, илт тод нээлттэй болгож, хүнээс хамаарах хамаарлыг багасгаж, хүнд суртлыг бууруулах бодлого баримтална.

- Үр ашиггүй төрийн инстүүцийг татан буулгаж, дэд сайд, орлогч дарга болон шаардлагагүй зөвлөхүүдийн орон тоог хасна.

- Мэргэжлийн, чадвартай ёс зүйтэй төрийн албан хаагчдыг төрд тогтвортой ажиллуулна. Ийм бололцоог хангахын тулд төрийн албаны зөвлөлийг хараат бус, бие даасан институци байгууллага болгоно.

- Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчийн ур чадварын шалгалтыг таван жил тутам зохион байгуулж, төрийн албан хаагчийн мерит зарчмыг тууштай мөрдүүлж, хэвшүүлнэ.

- Төрийн албан хаагчийг шалгаруулах шалгалтын агуулга, түвшинг дээшлүүлж, тухайн ажлын байранд шаардлагатай мэдлэг, чадварыг шалгасан агуулгатай болгоно.

- Төрийн албан хаагчдыг бэлдэх, тасралтгүй давтан сургана. Төрийн удирдлагын академийг гол зорилгод нь нийцүүлэн шинэчилж, бэхжүүлэх бодлого баримтална.

- Төрийн захиргааны албан хаагчийн дундаж цалинг амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээнд хүргэж, амьдралын баталгааг төрөөс хангах зорилт тавьж ажиллана. Төрийн ажил гацахгүй шуурхай явдаг, томилолт, томилгоо улс төрөөс ангид байх системийг бий болгож хэрэгжүүлнэ.

- Төрийн ёс зүй, сахилга бат, хариуцлага, мэдлэг чадвар, чармайлт бүхий төрийн тогтвортой албан хаагчдыг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлого, зорилт тавьж хэрэгжүүлнэ.

00000018

- Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.

#### 4.2 Хууль шүүхийн тогтолцоо – Эрх зүйн шинэтгэл

- Хүний эрх, эрх чөлөө, нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалтын эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, шинэтгэх зарчмыг хэрэгжүүлнэ.

- Эрх зүйн мэдээллийн үндэсний тогтолцоо бүрдүүлж боловсронгуй болгоно.

- Сонгон шалгаруулалт /тендер/, төрийн албан тушаалыг наймаалах, иргэдийн татварыг хулгайлж, эрх мэдэл болон төрийн нууцад хамаарах мэдээллийг урвуулан ашиглаж өөрт болон бусдад давуу байдал бий болгосон, татваргүй бүсэд байршуулсан валютыг /оффшор/ эх орондоо эргүүлэн оруулж ирэх хууль эрх зүйн орчныг бий болгох дээр дурдсан гэмт хэрэг үйлдсэн хүмүүст бүх насаар нь хорих ялаар шийтгэж хууль бусаар олсон эд хөрөнгийг улсын орлого болгох замаар улсын өр зээлийг төлнө.

- Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын удирдлагуудыг улс төрөөс хараат бус, бие даасан гагцхүү хууль дээдлэх зарчмыг үзэл баримтлал болгосон тогтолцоог бий болгохын тулд тус тусын байгууллагад бүтцийг бий болгох сонгон шалгаруулалтын эрхийг Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

- Авилга, ашиг сонирхлын хэргийг илрүүлэх механизмыг оновчтой болгох, түүнд оногдуулах ял шийтгэлийг чангатгана.

- Хууль зүй, дотоод хэргийн асуудлыг тусгаарлаж, эрх зүйн шинэтгэлийг хүний эрхийг хязгаарлах бус хангах чиглэлд явуулна.

- Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд хуулийн салбарт үүссэн гажуудлыг халж, хараат бус, хуульд төрд үнэнчээр зүтгэх, ёс зүйт хүний эрхийн төлөө хандлагатай албан хаагчдаар бүрдүүлэх, тэдний эрхийг хангах нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг бүрдүүлнэ.

- Эдийн засгийн эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, арилжааны хууль, шударга өрсөлдөөний болон картелийн эрх зүйн зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин зэргийг боловсронгуй болгох бодлого баримтална.

#### 4.3 Аюулгүй байдал – Батлан хамгаалах бодлого

- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалын зарчим, заалтуудыг мөрдлөг болгон дараах чиглэлд анхаарал хандуулна:

- Монгол Улсын Тусгаар тогтнол, Бүрэн эрхт байдал, Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарна. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндэс нь иргэдийн эх оронч үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулах чин эрмэлзэл, идэвхтэй үйл ажиллагаа байна.

- Газрын тос, хүнс, өргөн хэрэглээний барааны импортын хэт хамааралтай, түүхий эдийн экспорт голлосон, байгалийн баялаг, нөөцөд тавих хяналт алдагдсан, үндэсний үйлдвэрлэл, хөдөлмөрийн нөөц доройтсон, үнийн өсөлтөд өртөмтгий, газар зүйн хувьд түгжигдмэл зэрэг хэт өрөөсгөл, эмзэг бүтэц бүхий Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй байхад гол анхаарлаа хандуулна.

- Эдийн засгийн аюулгүй байдалд аюул учруулж буй гадаад, дотоод сөрөг хүчин зүйлүүдийг саармагжуулах, тэдгээрийн эсрэг дархлаа суулгах арга хэмжээг авч,

00000019

*[Handwritten signature]*



өөрийгөө тэнцвэржүүлэх чадвартай, эмзэг бус, бие даасан эдийн засагтай болгох бодлогын цогц арга хэмжээ авч, зөв зохистой тогтолцоог бүрдүүлнэ.

- Хөрш хоёр оронтой хамтран эдийн засгийн гурван талт харилцааг хөгжүүлэх, тэдгээрийн гаргасан санал санаачилгад оролцох боломж, давуу, болон сул талыг судалж, эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.
- “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд тэдгээр орны эдийн засгийн бодит ашиг сонирхлыг бий болгож, хамтарсан томоохон төслүүд хэрэгжүүлэх замаар харилцаагаа бататгах бодлого баримтална.
- Бүс нутгийн болон олон улсын байгууллагууд, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй байж, Монгол Улсын байр суурь, жин нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн алхмуудыг авч хэрэгжүүлнэ. Олон улсын дээд хэмжээний уулзалтууд, хурал, бусад хамтарсан арга хэмжээг хүлээн авч зохион байгуулах ажлыг тогтмолжуулах, улмаар Монгол Улсыг олон улсын яриа хэлэлцээний төв, зангилаа болгоход чиглэсэн алхмуудыг хэрэгжүүлнэ.
- Гадаад харилцаа эрхэлсэн төрийн төв байгууллагын болон төрийн бусад байгууллагын гадаад харилцааны асуудал хариуцсан ажилтнуудын боловсрол, мэдлэг, ур чадварт онцгойлон анхаарч, энэ чиглэлд мэргэшсэн байх шаардлага тавина.
- Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- Элчин сайдын томилгоо зэрэгт төрийн байгууллагууд, институцийн чиг үүрэг давхцаж буй өнөөгийн байдлыг цэгцэлж, эрх үүргийн тодорхой болгоно.
- УИХ-аас томилогдсон элчин сайдын хариуцлагыг тооцох механизмыг нарийвчлан тогтооно.
- Хүн төвтэй Үндэсний аюулгүй байдлын цогц бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.
- Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг нь хангана.
- Байгаль орчны болон хүнс, эм, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг эрс чангатгана.
- Үндэсний соёлын дархлаанд эрсдэл учруулж болох гадаадын хэт нөлөөнөөс монгол хүнийг хамгаалах зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлнэ.
- Батлан хамгаалах тогтолцоог олон улсын аюулгүй байдлын шинэ орчин, бүс нутгийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хөгжүүлнэ.
- Цэргийн шинжлэх ухаан, техник технологийн сүүлийн үеийн ололтуудыг тусгасан зэвсэглэл техникүүдээр армийг зэвсэглэх үе шаттай бодлогыг хэрэгжүүлнэ.
- Цэргийн насны залуучуудын эх оронч хүмүүжил, эрүүл мэнд боловсролыг сайжруулах асуудлыг цогцоор нь төгөлдөржүүлнэ.
- Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалахтай холбоотой хуулийн төслийг батлахдаа ард иргэддээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, дэвшилтэт технологи /гар утас, аппликэйшн/ ашиглан санал асуулга явуулж тухайн салбарын мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын санал дүгнэлтийг харгалзан үзэж хуулийн төслийг батална.

00000020

*JM*

- Батлан хамгаалах бодлогод түүхэн уламжлал, үндэсний болон газарзүйн онцлогийг дэлхий дахины хөгжил дэвшил, ололттой хослуулах зарчим баримталж, батлан хамгаалах салбарын шинэчлэлийг эрчимжүүлнэ.
- Батлан хамгаалах салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудал, орон сууцны асуудлыг өөрт нь болон улсын төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэнэ.
- Цэргийн болон хилийн тагнуулын байгууллагын ажиллагааг сайжруулж олон улсын нөхцөл байдалд зөв үнэлэлт дүгнэлт өгөх, хилээр үнэт метал, түүх соёлын өв, хар тамхи зэргийг хууль бусаар нэвтрүүлэх явдалтай хатуу тэмцэнэ.
- Зэвсэгт хүчинд орчин үеийн техник технологийн инновацийг нэвтрүүлнэ.
- Дотоодын цэргийн чадамжийг сэргээн сайжруулна.
- Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, хуулийг хэрэгжүүлнэ.

#### 4.4 Харилцан ашигтай гадаад бодлого

- Олон тулгуурт, нээлттэй, бие даасан идэвхтэй гадаад бодлого явуулж, улс орны аюулгүй байдал, тогтвортой хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлнэ.
- Хөрш орнуудтай түншлэлийн харилцаа бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- Гадаад улсад Монгол улсыг төлөөлж суух элчин сайдыг томилохдоо гадаад харилцааны салбартаа 15-аас доошгүй жил тухайн салбартаа ажилласан магистраас дээш эрдмийн зэрэгтэй урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй мэргэжлийн өндөр ёс зүйтэй хүнийг томилдог болгох.
- Дэлхийн олон улстай сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн зохистой түвшинд хүргэх бодлого баримтална.
- АНУ, Англи, Канад, Австрали, Ази болон Европын холбооны улсуудад аялал жуулчлалаар визгүй зорчих, тус улсын иргэд Монгол улсад тодорхой /14-30/ хоноогоор визгүй зорчих эрх зүйн үндсийг бий болгоно.
- Олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодис, хүний наймаа, байгаль орчны бохирдол зэрэг уламжлалт бус аюул заналтай тэмцэх талаар дэлхийн хамтын нийгэмлэгээс тавьж буй хүчин чармайлтад хувь нэмэр оруулахыг эрмэлзэж ажиллана.
- Монгол төр гадаадад суугаа Монголчуудынхаа талаар тодорхой бодлого боловсруулж, хөгжлийн бодлогын нэг хэсэг болгон ажиллана.
- Иргэндээ зориулсан төрийн үйлчилгээг гадаадад суудгаас үл хамааран хүргэх технологийн боломжийг ашиглана.
- Спорт, баяр наадам, соёлын арга хэмжээг тогтмол зохион байгуулах, олон нийтийн оролцоог хангах, хамтран ажиллана.

#### Тав. Нийслэл - орон нутгийн хөгжил

- Бодит байдалд тулгуурласан Шинжлэх ухааны үндэслэлтэй, урт хугацааны харилцан уялдаатай төлөвлөлтөөр нийслэл болон орон нутгийн төвүүдийг хөгжүүлэх бодлого барина.
- Нийслэлийн дэд төвүүдийг байгуулах замаар төвлөрлийг сааруулан, ард иргэд айл өрхүүдийг орон сууцжуулах урт хугацааны бодлого барин, агаар орчны бохирдлыг бууруулах талаар олон талт ажлууд хийнэ.

00000021

*(Handwritten signature)*

- Хөдөө орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл болон ажлын байруудыг тухайн орон нутгийн онцлогт нь тохируулан түлхүү байдлаар бий болгон, амьдрах орчинг нь сайжруулж, орон сууцны бичил хорооллуудыг бий болгох эхлэлийг үргэлжлүүлнэ.
- Бүс нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг гүнзгийрүүлж, бүс нутгуудын эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, хот хөдөөгийн хүн амын нийгэм соёлын харилцан уялдсан цогцолбор хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хотын төвийн хэсэгт орон нутгийн болон засгийн газрын өмчлөлд үлдсэн газрыг зөвхөн нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, спортын талбай, амралт зугаалгын ногоон байгууламж байгуулахад ашиглах тухай хуульчлан зохицуулна.
- Орон сууцны хороолол, гэр хорооллын дунд ногоон байгууламж, соёл, спортын төвүүдийг байгуулах талаар хүн амын тоо, нягтаршилтаас хамааруулан хүртээмжтэй байх стандарт батлуулж, мөрдүүлнэ.
- Агаар ба хөрсний бохирдлыг бүрэн шийдвэрлэх зорилгоор гэр хорооллыг хувийн сууц, нийтийн орон сууц хосолсон тохилог хороолол болгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ.
- Хаягдал усыг цэвэршүүлэх, саарал ус ашиглах, хурын усыг хуримтлуулах гэх мэт усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, усны төлбөрийг хөнгөлөх зохицуулалтыг хуульчилна.
- Хог хаягдлыг бууруулах, ангилан хаях, дахин ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг цуглуулах тогтолцоог ядуурлыг бууруулахтай уялдуулан хэрэгжүүлнэ.
- Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгохыг бодлогоор дэмжиж, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулна.
- Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлэх зорилгоор арга хэмжээ авна.
- Хотын ой санамжийг хадгалсан уран барилга, түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг шинэчлэн баталж, төрийн хамгаалалтанд авч, сэргээн засварлаж хойч үедээ өвлүүлэн үлдээх бодлого баримтлана.
- Иргэд, хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, нийтийн үйлчилгээний газар, орон сууцны нийтийн эзэмшлийн талбай зэрэгт эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын стандартыг чанд мөрдүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг хангах чиглэлээр олон улс болон Монгол Улсын хууль, журмыг баримталж нийтийн тээвэр, үйлчилгээний газар, сургууль цэцэрлэг, барилга байгууламж зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан норм дүрмийг ягштал мөрдүүлнэ.
- Нийтийн тээврийн хэрэгслийг тусгай эгнээгээр давуу эрхээр зорчуулж, үйлчилгээний хуваарийг тогтмолжуулна. Метро барих бодлогыг тууштай дэмжинэ.
- Явган хүний зам, дугуйн замын стандартыг мөрдүүлж, аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ.

00000022

- Олгож үл болох, хамгаалах шаардлагатай газрын жагсаалт үүсгэж, нийтийн хэрэгцээнд ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- Нийтийн орон сууцны хуучирсан барилгуудын гаднах фасадыг шинэчилж, стандартад нийцүүлэн дулаалж, сантехникийн шугам сүлжээг шинэчлэх замаар орон сууцны насжилтыг уртасгах ажлыг Зүүн Европын улсуудын жишгээр хувийн хэвшил, иргэдийн оролцоо, Нийслэлийн хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлд бонд гаргах замаар зохион байгуулах бодлого баримтална.
- Нягтаршилт хэтэрсэн орон сууцны хороололд ногоон байгууламж, тоглоомын талбай, амралт зугаалга, автомашины зогсоолоос өөр төрлийн барилга байгууламжийг шинээр барихыг хуулиар хориглоно.
- Орон сууцанд дулааны тоолуур тавих замаар өртөг зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- Шинэ суурьшлын бүс, дагуул хотыг хөгжүүлэхдээ төрийн өмчөөр зөвхөн төлөвлөлт хийж, дэд бүтцийг шийдвэрлэх ба барилгажилтын талбайг нээлттэйгээр дуудлага худалдаанд хамруулан хөрөнгө оруулалт босгох замаар орон сууцны хорооллыг өргөтгөнө.
- Залуу гэр бүлийн орлогод нийцсэн орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх бодлого баримтална.
- СӨХ-ийн тогтолцоог эргэж харан, гажуудлыг засч, төгөлдөршүүлнэ.
- Хүн амын талаас илүү нь оршин суудаг нийслэл хотын хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах суурь хэрэгцээг бүрдүүлэхэд хөрөнгө хуваарилалтыг чиглүүлэх бодлого баримтална.
- Гэр хорооллын иргэд хашаандаа цэвэр бохирын бие даасан шийдэл бүхий дулаан сууц барихад ипотекийн зээл олгох ажлыг өргөн цар хүрээтэйгээр хэрэгжүүлэх хуулийн төслийг боловсруулан өргөн барина.
- Гэр хорооллын иргэд хоршоо байгуулж, өөрсдийн эзэмшлийн газартаа хэсэгчилсэн дэд бүтцийн шийдэлтэй орон сууцны хороолол байгуулж, зарим хэсгийг борлуулан ашиг олох эрх зүйн орчинг бүрдүүлэх хууль санаачилна.
- Хүн ам цөөтэй, эх газрын эрс тэс уур амьсгалтай, экологийн эмзэг орчин бүхий уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагтай Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлж, засаг захиргааны олон жижиг нэгжийг томсгон, сум дундын болон аймгийн, бүсийн төвүүд зэрэг хот суурин газрыг хөгжүүлснээр хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгах бодлого баримтална.
- Хөдөө орон нутгийн өөртөө засах эрхийг нэмэгдүүлж, малын хөлийн татвар зэрэг боломжтой гэсэн татварыг хөдөө орон нутгийн хөгжилд зарцуулах эрхийг тухайн орон нутагт нь олгох, тухайн бүсийн байгалийн баялгийн нөөцийг ашигласны эцсийн үр өгөөжийг байгаль орчныг хамгаалахад зарцуулж, экологийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлнэ.

00000023



## Мөрийн хөтөлбөр хэрэгжих баталгаа

Стратегийн ач холбогдолтой томоохон ордуудыг ашиглахдаа зөвхөн Монголын ард түмний нийтийн өмч болгон өнөөгийн ба ирээдүй хойч үеийн иргэдийн нийтлэг эрх ашгийг хангах зорилттой нийцүүлнэ. Байгалийн баялаг ард түмний нийтийн өмч болсноор ядуурлын асуудал бүрмөсөн шийдэгдэнэ

Өвөг дээдсийн алтан амиа золиосолсон их тэмцэл, хөдөлмөрийн үр дүнд Та бидэнд уламжлагдан ирсэн туурга тусгаар Монгол Улс маань өргөн уудам газар нутагтай, арвин их байгалийн баялагтай бөгөөд хүн ард нь авьяас чадвартай билээ. Бидний улс дэлхий дахины хөгжилтэй улс орны нэгэн адил эрчимтэй хөгжих, ард түмэн нь чинээлэг амьдрах бүрэн бололцоотой гэдгийг Та бид гүнээ ухамсарлаж байгаа юм. Та бид юуны түрүүн төр засгийн бүрэн эрхийг итгэл үнэмшилтэй сонголтоороо эдэлж, хариуцлагатай төр засгийг ард түмний хүсэл зоригоор эмхлэн байгуулах нь энэхүү мөрийн хөтөлбөр хэрэгжих хамгийн том баталгаа – Монгол Улсын хөгжлийн дотоод хүчин зүйл мөн.

Манай улсын хоёр хөрш, ойр зэргэлдээ гурав дахь хөршүүдийн эдийн засгийн хөгжил нь дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүрч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь хурдтайгаар нэмэгдэж байгаа нь Та бидний Мөрийн хөтөлбөрийн зорилтууд хэрэгжихэд таатай гадаад хүчин зүйл мөн.

Монгол Улсыг хөгжүүлэх хамгийн гол нөөц баялаг, хүч бол манай улсын иргэд мөн. Төрийн албанд улс орноо хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавьж чаддаг хүмүүсийг тогтвортой ажиллуулна. Та бид шинэчлэлийг хэрэгжүүлэх Монгол хүний саруул ухаанд итгэх ёстой.

## Мөрийн хөтөлбөр хэрэгжих санхүүгийн эх үүсвэр, тооцоолол

МОНГОЛ ШИНЭЧЛЭЛТ НАМЫН сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол улс болон сонгогч иргэдэд тулгамдаад байгаа зайлшгүй яаралтай шийдвэрлэх асуудлуудыг онцгойлон анхаарахад чиглэгдсэн бөгөөд хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, МУ-ын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, тайлан, шаардагдах зардлын талаархи тооцоо судалгаанд тулгуурласан нь хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд бүрэн боломжтой болно.

Эрхэм хүндэт сонгогчид оо!

Бид 32 жилийн хугацаанд ИТГЭСЭН, НАЙДСАН, ЦӨХӨРСӨН, ХУУРТАГДСАН !!!

Сонгогч та бүхэн МОНГОЛ ШИНЭЧЛЭЛТ намыг итгэл хүлээлгэн багаар нь дэмжиж УИХ-д олонх болговол бид үүсээд байгаа тогтолцооны гажуудлыг засаж шударга, ёс зүйтэй, үүрэг хариуцлагаа ухамсарласан, МОНГОЛ ХҮНЭЭ хайрлан хамгаалсан төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Сонгогч та бүхнийг 2024 онд Монгол улсаа ХАМТДАА ШИНЭЧЛЭХ-ийг уриалж байна!

00000024